



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2024 оны 05 сарын 30 өдөр

Дугаар 267

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Говь-Алтай аймгийн Прокурорын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 22,000,000.00 (хорин хоёр сая) төгрөгийн балансын үнэ, 20,166,666.67 (хорин сая нэг зуун жаран зургаан мянга зургаан зуун жаран зургаан төгрөг жаран долоон мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий Ниссан Патрол Y-61 маркийн, 02-75 ГАҮ улсын дугаартай, JN1TCSY61Z0581008 арлын дугаартай тээврийн хэрэгслийг "Алтай-Улиастайн эрчим хүчний систем" төрийн өмчит хувьцаат компанид балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Говь-Алтай аймгийн Прокурорын газрын ерөнхий прокурорын орлогч Д.Ганцэцэг, "Алтай-Улиастайн эрчим хүчний систем" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Б.Цэдэвсүрэн нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.3. Тээврийн хэрэгслийг татвар төлөгчийн бүртгэл, улсын бүртгэлээс шилжүүлж арга хэмжээний биелэлтийг 2024 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

132001185
15-r_huraldaan.docx